



МОНГОЛ УЛСЫН
БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙДЫН
ТУШААЛ

2021 оны 04 сарын 26 өдөр

Дугаар A/95


Улаанбаатар хот

Г
Батлан хамгаалах салбарын
бодлогын баримт бичгийн хэрэгжилт, байгууллагын
үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх
аргачлал батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 2, Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны "Журам батлах тухай" 206 дугаар тогтоолын 2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Батлан хамгаалах салбарын бодлогын баримт бичгийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх аргачлалыг хавсралтаар баталсугай.
2. Энэ аргачлалыг үндэслэн Зэвсэгт хүчний үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх аргачлал боловсруулан баталж мөрдүүлэхийг Зэвсэгт хүчний Жанжин штаб /хошууч генерал Д.Ганзориг/-т даалгасугай.
3. Тайлан, мэдээллийн үнэн бодит байдлыг хангаж, байгууллагын даргын зөвлөл, удирдлагын хуралдаанаар хэлэлцүүлсэн тэмдэглэлийн хамт албажуулан ирүүлж байхыг яамны харьяа агентлаг, төсөвт болон төрийн өмчит аж ахуйн нэгж, байгууллагуудын дарга /захирал/ нарт үүрэг болгосугай.
4. Энэ тушаал гарсантай холбогдуулан Батлан хамгаалахын сайдын "Баримт бичиг тайлагнах хугацааг шинэчлэн тогтоох, гэмт хэрэг, осол зөрчлийг шуурхай мэдээлэх тухай" 2017 оны А/121, "Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам батлах тухай" 2019 оны А/375 дугаар тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.
5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /хурандаа Б.Эрхэмбаяр/-т даалгасугай.

САЙД



Г.САЙХАНБАЯР

1321100231

Батлан хамгаалахын сайдын 2021 оны
04 дүгээр сарын 16.-ний өдрийн
A/95.дугаар тушаалын хавсралт

**БАТЛАН ХАМГААЛАХ САЛБАРЫН БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ,
БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭ ХИЙХ АРГАЧЛАЛ**

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго, зарчим

1.1.Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг (цаашид “бодлогын баримт бичиг” гэх), Монгол Улсын хууль, УИХ-ын шийдвэр, Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, Засгийн газрын шийдвэр (цаашид “хууль тогтоомж, тогтоол, шийдвэр” гэх)-т батлан хамгаалах чиглэлээр тусгагдсан зорилт, арга хэмжээ, Батлан хамгаалахын сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлын төлөвлөгөө, хуралдааны шийдвэрийн хэрэгжилт, Батлан хамгаалахын сайд, Төрийн нарийн бичгийн даргын тушаал /цаашид захирамжлалын баримт бичиг гэх/, байгууллагын стратеги болон гүйцэтгэлийн төлөвлөгөө, сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлын төлөвлөгөө, хуралдааны шийдвэр /цаашид төлөвлөлтийн баримт бичиг гэх/-ийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үр дүнг үнэлж дүгнэхэд энэхүү аргачлалыг баримтална.

1.2.Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго нь батлан хамгаалах бодлогыг хэрэгжүүлэх төлөвлөлт, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүнг нэмэгдүүлэх, удирдлагыг бодит мэдээллээр хангах, бүтцийн нэгжүүдийн ажлын уялдааг хангах, албан хаагчдын ажлын хариуцлагыг өндөржүүлэх, байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлэхэд оршино.

1.3.Хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхдээ дараах зарчмыг баримтална:

- 1.3.1.шударга, хараат бус байх;
- 1.3.2.шалгуур үзүүлэлт, тоо баримт, судалгаа, шинжилгээнд үндэслэсэн байх;
- 1.3.3.нээлттэй, тайлан дүгнэлт нь ил тод, тухайн бодлого, үйл ажиллагааны үр дүн, үр нөлөөг тодорхойлсон, нотлогдохуйц байх;
- 1.3.4.хяналт-шинжилгээг тасралтгүй, үнэлгээг тодорхой үе шаттай, тогтмол хийх;
- 1.3.5.тайландаа тусгагдсан мэдээллийн үнэн зөв байдлыг холбогдох нэгж, албан тушаалтан хариуцдаг байх.

Хоёр. Хяналт шинжилгээ, үнэлгээний зорилтууд

2.1.Бодлогын баримт бичгүүдэд батлан хамгаалах чиглэлээр тусгагдсан зорилт, арга хэмжээнүүд, хууль тогтоомж, тогтоол, шийдвэр, хөтөлбөр, төслүүд, захирамжлалын болон төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн явцыг урьдчилан тодорхойлсон шалгуур үзүүлэлтийн дагуу хянах, мэдээлэх;

2.2.Байгууллагын үйл ажиллагаа, бодлогын баримт бичгийн зорилго, зорилтын хэрэгжилтийн явцыг төлөвлөсөн зорилтот түвшиндээ хүрсэн эсэхэд дүн шинжилгээ хийж үнэлэлт өгөх;

2.3.Бодлогын зорилт, төлөвлөсөн арга хэмжээнүүд нь зорилтот түвшиндээ хүрээгүй эсвэл удаашралтай байгаа тохиолдолд шалтгаан нөхцөлийг тодорхойлж, тэдгээрийг эрчимжүүлэх, үр дүнг сайжруулах дүгнэлт, зөвлөмжийг боловсруулж, удирдлагад төлөвлөлт, зохицуулалт, зохион байгуулалтын арга хэмжээ авах, шийдвэр гаргахад нь дэмжлэг үзүүлэх.

Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний хамрах хүрээ

3.1.Хяналт-шинжилгээ, үнэлгээний хамрах хүрээнд дараах бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол, шийдвэр, захирамжлалын баримт бичиг, байгууллагын үйл ажиллагаа багтана.

3.1.1.Бодлогын баримт бичигт:

3.1.1.1.Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050”;

3.1.1.2.Хөгжлийн зорилтот хөтөлбөр;

3.1.1.3.Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл;

3.1.1.4.Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр;

3.1.1.5.Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө;

3.1.1.6. хөтөлбөр, төсөл

3.1.2.Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрт:

3.1.2.1.Монгол Улсын хууль;

3.1.2.2.Улсын Их Хурлын тогтоол;

3.1.2.3.Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол;

3.1.2.4.Ерөнхийлөгчийн зарлиг;

3.1.2.5.Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн шийдвэр;

3.1.2.6.Засгийн газрын тогтоол;

3.1.2.7.Ерөнхий сайдын захирамж;

3.1.2.8.Засгийн газрын хуралдааны тэмдэглэл;

3.1.2.9.Засгийн газрын болон Ерөнхий сайдын албан даалгавар.

3.1.3.Төлөвлөлт, захирамжлалын баримт бичигт:

3.1.3.1.Салбарын стратеги төлөвлөгөө;

3.1.3.2.Байгууллагын стратеги төлөвлөгөө;

3.1.3.3.Зэвсэгт хүчний байгуулалтыг хөгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө;

3.1.3.4.Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө;

3.1.3.5.Батлан хамгаалахын сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлын төлөвлөгөө, хуралдааны шийдвэрийн хэрэгжилт

3.1.3.6.Батлан хамгаалахын сайдын тушаал;

3.1.3.7.Яамны Төрийн нарийн бичгийн даргын тушаал;

3.1.4.Байгууллагын үйл ажиллагаанд:

3.1.4.1.энэ аргачлалын 3.1.1, 3.1.2-т заасан баримт бичгийн хүрээнд хэрэгжүүлсэн үйл ажиллагаа;

3.1.4.2.эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн биелэлт;

3.1.4.3.стратеги төлөвлөгөөний биелэлт;

3.1.4.4.байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт;

3.1.4.5.ил тод байдлыг хангах талаар хэрэгжүүлсэн үйл ажиллагаа;

3.1.4.6.Батлан хамгаалахын сайдаас аймаг, нийслэлийн Засаг дарга нартай байгуулсан гэрээний үүргийн биелэлт;

3.1.4.7.төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт.

3.2.Хяналт-шинжилгээ, үнэлгээг Батлан хамгаалахын сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсөвт болон төрийн өмчит байгууллагын үйл ажиллагааны хүрээнд хийнэ.

Дөрөв. Хяналт-шинжилгээ, үнэлгээний удирдлага,
зохион байгуулалт

4.1.Стратегийн бодлого, төлөвлөлтийн газар нь салбарын болон яамны стратеги төлөвлөгөөний хэрэгжилт, Батлан хамгаалахын сайдаас аймаг, нийслэлийн Засаг дарга нартай байгуулсан гэрээний үүргийн биелэлтийг, Төрийн захиргааны удирдлагын газар нь бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол, шийдвэр, захирамжлалын баримт бичиг, төсөл хөтөлбөрийн хэрэгжилт, сайдын өгсөн үүргийн биелэлт, байгууллагын гүйцэтгэлийн тайланг нэгтгэн боловсруулж, хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт хүргүүлнэ.

4.2.Төлөвлөгөө боловсруулах, түүний гүйцэтгэлийг тайлагнаадаа Засгийн газрын 2020 оны 216 дугаар тогтоолоор батлагдсан “Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам”, 217 дугаар тогтоолоор батлагдсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалаар батлагдсан загвар, аргачлалыг баримтална.

4.3.Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн болон төлөвлөлт, захирамжлалын баримт бичгийн хэрэгжилтийг тухайн зорилт, арга хэмжээ, заалт бүрийн гүйцэтгэл, үр дүнг хоёр мянган тэмдэгтэд багтаан товч, тодорхой тайлагнана. Тухайн зорилт, арга хэмжээ, заалтын хэрэгжилт зорилтот түвшиндээ хүрээгүй бол шалтгааныг бичнэ.

4.4.Төрийн албан хаагч бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагааны тайлан, холбогдох мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж өгөх үүрэгтэй бөгөөд мэдээллийн үнэн зөв, бодит байдлыг хариуцна.

4.5.Тайлан, мэдээллийг гаргасан, нэгтгэсэн албан тушаалтан гарын үсэг зурж, албажуулан холбогдох нэгж, албан тушаалтанд хэвлэмэл болон цахим хэлбэрээр хүргүүлнэ.

4.6.Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол, шийдвэр, төлөвлөлт, захирамжлалын баримт бичиг, төсөл хөтөлбөр, сайдын өгсөн үүргийн биелэлт, яам, харьяа төсөвт болон төрийн өмчит байгууллагын үйл ажиллагаанд Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, сайдын зөвлөл, удирдлагын хурлаар хэлэлцүүлэн тайланг холбогдох дээд байгууллагуудад хүргүүлж, Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим санд оруулж баталгаажуулна.

4.7.Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн нэгж, албан тушаалтан нь цаашид авах арга хэмжээний талаарх санал, зөвлөмжийг холбогдох байгууллага, бүтцийн нэгжүүдэд хүргүүлнэ.

4.8.Шаардлагатай тохиолдолд, эсвэл удирдлагын шийдвэрээр тодорхой чиглэлээр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ яам, Зэвсэгт хүчний Жанжин штабын албан хаагч, холбогдох мэргэжлийн байгууллагууд, эрдэмтэн судлаачдын төлөөллийг оролцуулан хамтарсан ажлын хэсэг байгуулж болно.

Тав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний төлөвлөлт, арга зүй

5.1.Хяналт-шинжилгээ, үнэлгээний төлөвлөлт, төрөл:

5.1.1.Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгжүүд нь жил бүр хяналт-шинжилгээ, үнэлгээний төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг зохион байгуулна. Энэхүү төлөвлөгөө нь тухайн нэгжийн төлөвлөгөө байж болно.

5.1.2.Үнэлгээний зорилгоос хамааран үр дүнд суурилсан явцын болон эцсийн үнэлгээ хийх бөгөөд төлөвлөгөөнд ямар төрлийн үнэлгээ хийх талаар нарийвчлан тусгана.

5.2. Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй:

5.2.1.Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээ, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн зүйл заалтын хэрэгжилт, Батлан хамгаалахын сайдаас аймаг, нийслэлийн Засаг даргатай байгуулсан гэрээний үүргийн биелэлт, байгууллагын стратеги болон гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, тухайн жилийн үйл ажиллагааг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д заасан аргачлалыг баримтлан урьдчилан тодорхойлсон шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлнэ.

5.2.2.Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээ, хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтэд хоёр удаагийн тайлангийн хугацаанд дараалан ахиц гараагүй бол удааширан, гурван удаагийн тайлангийн хугацаанд мөн ахиц гараагүй бол тасарсанд тооцно.

Зургаа. Бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх

6.1.Бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үйл ажиллагааны зорилго нь баримт бичгийн төлөвлөлт, гүйцэтгэл, хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, шийдвэр нь үр дүнтэй байсан эсэхэд чанарын үнэлгээ хийх, үр нөлөөг үнэлэхэд оршино.

6.2.Бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтэд дараах үе шатаар цогц хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ:

6.2.1.мэдээлэл цуглуулах, ангилах, нэгтгэх;

6.2.2.зорилтын биелэлтийн дүнг үнэлэх;

6.2.3.биелэлтийн үр нөлөөг үнэлэх;

6.2.4.гадаад, дотоод хүчин зүйлийн нөлөөллийг үнэлэх;

6.2.5.төлөвлөлт, хэрэгжилтийн харилцан хамаарлыг үнэлэх;

6.2.6.биелэлтийн түвшинг үнэлэх;

6.2.7.бодлогын баримт бичгийн төлөвлөлт, хэрэгжилтийг сайжруулах санал боловсруулах.

6.3.Энэ аргачлалын 3.1.1-д заасан бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн тайланг холбогдох нэгжүүд 1 дүгээр хавсралтад заасан хугацаанд 2, 3 дугаар

хавсралтын дагуу гаргаж Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт ирүүлнэ.

Зэвсэгт хүчний Хяналт-шинжилгээ, үнэлгээний газар нь бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн жилийн эцсийн үр дүнд хяналт-шинжилгээ үнэлгээ хийж, тайланг 1 дүгээр хавсралтад заасан хугацаанд Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт ирүүлнэ.

6.4.Үндэсний хэмжээнд хэрэгжих бодлогын баримт бичиг:

6.4.1.Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050” баримт бичиг болон хөгжлийн зорилтот хөтөлбөрт батлан хамгаалах чиглэлээр тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн явцад:

6.4.1.1.Яамны бүтцийн нэгжүүд, Зэвсэгт хүчний Жанжин штаб, яамны харьяа төсөвт болон төрийн өмчтэй байгууллагууд өөрийн эрхлэх асуудлын хүрээнд тайлан гаргаж, Төрийн захиргааны удирдлагын газарт хүргүүлнэ.

6.4.1.2.Төрийн захиргааны удирдлагын газар батлан хамгаалах салбарын хэмжээний тайланг жил бүр нэгтгэж, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт ирүүлнэ.

6.4.1.3.Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар нэгдсэн тайланг хянаж, жил тутамд хяналт-шинжилгээ хийж, дүнг удирдлагад танилцуулах бөгөөд таван жил тутамд үнэлгээ хийж, тайланг Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

6.4.2.Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд батлан хамгаалах чиглэлээр тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн явцад:

6.4.2.1.Яамны бүтцийн нэгжүүд, Зэвсэгт хүчний Жанжин штаб, яамны харьяа төсөвт болон төрийн өмчтэй байгууллагууд өөрийн эрхлэх асуудлын хүрээнд тайлан гаргаж, Төрийн захиргааны удирдлагын газарт хүргүүлнэ.

6.4.2.2.Төрийн захиргааны удирдлагын газар батлан хамгаалах салбарын хэмжээний тайланг хагас, бүтэн жилээр нэгтгэж, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт ирүүлнэ.

6.4.2.3.Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар хагас, бүтэн жилээр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүнг удирдлагад танилцуулах бөгөөд жилийн эцсийн үнэлгээний тайланг Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

6.4.3.Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд батлан хамгаалах чиглэлээр тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн явцад:

6.4.3.1.Яамны бүтцийн нэгжүүд, Зэвсэгт хүчний Жанжин штаб, яамны харьяа төсөвт болон төрийн өмчтэй байгууллагууд өөрийн эрхлэх асуудлын хүрээнд тайлан гаргаж, Төрийн захиргааны удирдлагын газарт хүргүүлнэ.

6.4.3.2.Төрийн захиргааны удирдлагын газар батлан хамгаалах салбарын хэмжээний тайланг улирал тутамд нэгтгэн гаргаж, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт ирүүлнэ.

6.4.3.3.Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар улирал тутамд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүнг удирдлагад танилцуулах бөгөөд хагас, бүтэн жилийн үнэлгээний тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ.

6.4.4. Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд батлан хамгаалах чиглэлээр тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн явцад:

6.4.4.1. Яамны бүтцийн нэгжүүд, Зэвсэгт хүчний Жанжин штаб, яамны харьяа төсөвт болон төрийн өмчит байгууллагууд өөрийн эрхлэх асуудлын хүрээнд тайлан гаргаж, Төрийн захиргааны удирдлагын газарт хүргүүлнэ.

6.4.4.2. Төрийн захиргааны удирдлагын газар батлан хамгаалах салбарын хэмжээний тайланг улирал тутамд нэгтгэж, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт ирүүлнэ.

6.4.4.3. Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар улирал тутамд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүнг удирдлагад танилцуулах бөгөөд хагас, бүтэн жилийн үнэлгээний тайланг Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

6.4.5. Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад:

6.4.5.1. Яамны бүтцийн нэгжүүд, Зэвсэгт хүчний Жанжин штаб, яамны харьяа төсөвт болон төрийн өмчит байгууллагууд өөрийн эрхлэх асуудлын хүрээнд гадаадын зээл, тусlamжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн тайланг Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт, Улсын Их хурал, Засгийн газар, Батлан хамгаалахын сайдын тушаалаар батлагдсан төсөл, хөтөлбөрийн тайланг Төрийн захиргааны удирдлагын газарт тус тус хүргүүлнэ.

6.4.5.2. Төрийн захиргааны удирдлагын газар нь Улсын Их хурал, Засгийн газар, Батлан хамгаалахын сайдын тушаалаар батлагдсан төсөл, хөтөлбөрийн тайланг, Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар батлан хамгаалах салбарт гадаадын зээл, тусlamжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн тайланг нэгтгэж, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт ирүүлнэ.

6.4.5.3. Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар гадаадын зээл, тусlamжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд жилд нэг удаа хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж тайланг Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад, Улсын Их хурал, Засгийн газар, Батлан хамгаалахын сайдын тушаалаар батлагдсан төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд жилд 2 удаа хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж тайланг холбогдох байгууллагуудад тус тус хүргүүлнэ.

Долоо. Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтэд
хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх

7.1. Төрийн захиргааны удирдлагын газар хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийг хяналтад авч, холбогдох нэгж, байгууллагуудад хүргүүлэн хэрэгжилтэд нь хяналт тавьж, улирал тутамд тайланг нэгтгэн, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт ирүүлнэ.

7.2. Яамны бүтцийн нэгжүүд, Зэвсэгт хүчний Жанжин штаб, харьяа төсөвт болон төрийн өмчит аж ахуйн нэгж, байгууллагууд хууль тогтоомж, тогтоол шийдвэр, тэдгээрт нийцүүлэн гаргасан шийдвэрийн биелэлтийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, тайланг Төрийн захиргааны удирдлагын газарт хүргүүлнэ.

7.3. Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн явцад улирал тутамд хяналт-шинжилгээ,

үнэлгээ хийх бөгөөд хагас, бүтэн жилийн үнэлгээний тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ.

Найм. Төлөвлөлт, захирамжлалын баримт бичиг, сайдын өгсөн үүргийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх

8.1.Стратегийн бодлого, төлөвлөлтийн газар нь салбарын болон байгууллагын стратеги төлөвлөгөөний хэрэгжилт, Батлан хамгаалахын сайдаас аймаг, нийслэлийн Засаг даргатай байгуулсан гэрээний үүргийн биелэлтийн тайланг жил бүр, Төрийн захиргааны удирдлагын газар яамны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг хагас, бүтэн жилээр, Зэвсэгт хүчний байгуулалтыг хөгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн явцыг улирал тутам, Батлан хамгаалахын сайд, Төрийн нарийн бичгийн даргын тушаалын биелэлтийг сар бүр, сайдын өгсөн үүргийн хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр нэгтгэн гаргаж, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт ирүүлнэ.

8.2.Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар нь:

8.2.1.салбарын болон байгууллагын стратеги төлөвлөгөөний хэрэгжилтэд жил бүр хяналт-шинжилгээ хийж, дүнг удирдлагад танилцуулах бөгөөд 4 жилд 1 удаа хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ.

8.2.2.яам, Зэвсэгт хүчний Жанжин штаб, харьяа төсөвт болон төрийн өмчит байгууллагуудын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд жилд 2 удаа хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүнг удирдлагад танилцуулна. Яамны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хийсэн жилийн эцсийн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ.

8.2.3.Зэвсэгт хүчний байгуулалтыг хөгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн явц, Батлан хамгаалахын сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлын төлөвлөгөө, хуралдааны шийдвэрийн хэрэгжилтэд улирал бүр, сайд, Төрийн нарийн бичгийн даргын тушаалын хэрэгжилтэд сар тутамд, сайдын өгсөн үүргийн хэрэгжилтэд жилд 2 удаа хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүнг удирдлагад танилцуулна.

8.3.Зэвсэгт хүчний Хяналт-шинжилгээ, үнэлгээний газар нь Зэвсэгт хүчний байгуулалтыг хөгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн явц, Зэвсэгт хүчний Жанжин штабын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хагас, бүтэн жилээр хяналт-шинжилгээ үнэлгээ хийж, тайланг 1 дүгээр хавсралтад заасан хугацаанд Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт ирүүлнэ.

**Ес. Байгууллагын үйл ажиллагаанд
хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх**

9.1.Төрийн захиргааны удирдлагын газар нь яамны үйл ажиллагааны тайланг, харьяа төсөвт болон төрийн өмчит аж ахуйн нэгж, байгууллагууд үйл ажиллагааныхаа тайланг тус тус Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт ирүүлнэ. Тайлан нь дараах хавсралттай байна:

9.1.1.байгууллагын тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт;

9.1.2.төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт;

9.1.3.байгууллагын ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн биелэлт.

9.2.Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар яам, түүний харьяа төсөвт болон төрийн өмчит аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүнг сайдын зөвлөл, удирдлагын хуралд танилцуулна.

9.3.Зэвсэгт хүчний Хяналт-шинжилгээ, үнэлгээний газар нь Зэвсэгт хүчний Жанжин штаб, Төрлийн цэргийн командлал /удирдах газар/-ын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх бөгөөд Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлтэд хийсэн хяналт-шинжилгээ үнэлгээний тайланг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт ирүүлнэ.

9.4.Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар нь Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын нэгтгэн ирүүлсэн “Батлан хамгаалахын сайдаас аймаг, нийслэлийн Засаг даргатай байгуулсан гэрээ”-ний үүргийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ.

9.5.Төрийн захирагааны удирдлагын газар нь яамны төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлтийн тайланг энэ аргачлалын 5 дугаар хавсралтын дагуу гаргаж, 1 дүгээр хавсралтад заасан хугацаанд Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт ирүүлнэ.

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар нь яамны төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлтэд үнэлгээг хийж, тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ.

9.6.Төрийн захирагааны удирдлагын газар нь яамны, харьяа төсөвт болон төрийн өмчит аж ахуйн нэгж, байгууллагууд байгууллагынхаа ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийн тайланг энэ аргачлалын 6 дугаар хавсралтын дагуу гаргаж Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт ирүүлнэ.

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар нь яам, ЗХЖШ, харьяа байгууллагуудын ил тод байдлын үнэлгээг хийнэ.

9.7.Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд улирал тутамд, архив, албан хэрэг хөтлөлтийн дүрэм, журам, зааврын хэрэгжилтэд жилд 1 удаа хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлгэнэ.

9.8.ЗХЖШ, харьяа төсөвт болон төрийн өмчит аж ахуйн нэгж, байгууллагууд “Ажлын байрны таатай орчны сэтгэл ханамжийн санал асуулга”-ыг жилд нэг удаа албан хаагчдынхаа 80-аас доошгүй хувийг хамруулан жилд 1 удаа зохион байгуулж, тайланг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт ирүүлнэ.

Арав. Бусад тайлан, мэдээ

10.1.Зэвсэгт хүчний Жанжин штаб, яамны харьяа төсөвт болон төрийн өмчит аж ахуйн нэгж, байгууллагууд дараах тайлан, мэдээг энэ аргачлалын 1 дүгээр хавсралтад заасан хугацаанд ирүүлнэ.

10.1.1.Батлан хамгаалахын өрөнхий хянан шалгагч, яамны төрийн албан хаагчийн ёс зүйн зөвлөлийн даргад:

- 10.1.1.1.төрийн албан хаагчийн ёс зүйн зөвлөлийн үйл ажиллагаа /ёс зүйн зөвлөлгүй бол төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиулах талаар хэрэгжүүлсэн арга хэмжээ/-ны улирлын тайлан;
- 10.1.1.2.төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлийн улирлын мэдээ;
- 10.1.1.3.ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, сурталчлан таниулах сургалт, сурталчилгааны ажлын сарын мэдээ;

10.1.2.Батлан хамгаалахын дэд сайд, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, дэг журам, сахилга, хариуцлагыг бэхжүүлэх салбар зөвлөлийн даргад:

10.1.2.1.Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, дэг журам, сахилга, хариуцлагыг бэхжүүлэх салбар зөвлөлийн үйл ажиллагааны улирлын тайлан;

10.1.2.2.Гэмт хэрэг, осол, зөрчлийн сарын мэдээ.

10.2.Төрийн албан хаагчийн ёс зүйн болон Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, дэг журам, сахилга, хариуцлагыг бэхжүүлэх салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга тайлан, мэдээг улирал бүр нэгтгэж, хагас, бүтэн жилийн нэгдсэн тайлан, мэдээг холбогдох дээд байгууллагуудад хүргүүлнэ.

**Арван нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний
үр дүнг хэрэгжүүлэх**

11.1.Яам, Зэвсэгт хүчний Жанжин штаб, харьяа төрийн болон төрийн өмчит аж ахуйн нэгж, байгууллага нь хяналт-шинжилгээ, үнэлгээний тайландаа дурдсан зөвлөмж, дүгнэлтийн дагуу холбогдох арга хэмжээг авч дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

11.1.1.тэргүүний арга, туршлагыг түгээн дэлгэрүүлэх, гарсан алдаа, дутагдлыг засах;

11.1.2.байгууллагынхаа үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулах;

11.1.3. үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх талаар харьяа байгууллагууддаа байгууллагын үүрэг, чиглэл өгөх, шаардлагатай тохиолдолд газар дээр нь хяналт шалгалах хийж, дүгнэлт гаргах.

11.2.Бүтцийн нэгжүүд, ЗХЖШ, харьяа төсөвт болон төрийн өмчит байгууллага нь хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлт, зөвлөмжид үндэслэн бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол, шийдвэр, төлөвлөлт, захирамжлалын баримт бичиг, төсөл хөтөлбөр, сайдын өгсөн үүргийн хэрэгжилтийг эрчимжүүлж биелэлтийг хангах, нэмэлт, өөрчлөлт оруулах болон шаардлагатай бусад арга хэмжээг авах үйл ажиллагааг зохион байгуулна.

Арван хоёр. Хариуцлага

13.1.Дараах зөрчил гаргасан албан тушаалтанд Төрийн албаны тухай болон холбогдох бусад хуульд зааснаар хариуцлага хүлээлгэнэ:

13.1.1.тайлан, мэдээг хугацаанд нь ирүүлээгүй;

13.1.2.худал, зөрүүтэй тайлан, мэдээ ирүүлсэн;

13.1.3.өгсөн дүгнэлт, зөвлөмжийг биелүүлээгүй;

Аргачлалын 1 дүгээр хавсралт

**БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ, ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ,
БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ТАЙЛГНАХ ХУГАЦАА**

Д/Д	Тайлангийн төрөл	Хэрэгжилтийн нэгдсэн тайлан ирүүлэх нэгж	Хугацаа /сар. өдөр/	ХШҮ-ний тайлан ирүүлэх нэгж	Хугацаа /сар. өдөр/
Нэг. Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэр					
1.1	Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050”	ТЗУГ	08.01	3Х-ий ХШҮГ	08.01
1.2	Хөгжлийн зорилтот хөтөлбөр	ТЗУГ	09.01	3Х-ий ХШҮГ	09.01
1.3	“Монгол Улсын Батлан хамгаалахын хөгжлийн үндэс” баримт бичиг	ТЗУГ, СБТГ	01.10, 06.25		
1.4	“Төрийн цэргийн байгууллагын хөгжлийн стратеги-2030” баримт бичиг	ТЗУГ	01.10, 06.25		
1.5	Төрөөс орон нутгийн хамгаалалтын талаар баримтлах болдого	СБТГ	01.10, 06.25		
1.6	Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл	ТЗУГ	01.20, 06.20	3Х-ий ХШҮГ	01.20
1.7	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хөгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө	ТЗУГ	01.05, 04.20	3Х-ий ХШҮГ	12.25
1.8	Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө	ТЗУГ	01.05, 04.20	3Х-ий ХШҮГ	01.10
1.9	Хууль тогтоомж, тогтоол шийдвэр	ТЗУГ	04.01, 06.20		
Хоёр. Хөтөлбөр, төсөл					
2.1	УИХ, Засгийн газрын тогтоолоор батлагдсан үндэсний хөтөлбөр	ТЗУГ	05.25, 12.15		
2.2	Батлан хамгаалахын сайдын тушаалаар батлагдсан хөтөлбөр, төсөл	ТЗУГ	03.25, 07.01	3Х-ий ХШҮГ	12.20
2.3	Гадаадын зээл, туслаамжаар хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөр	БХЗГ	10.25, 12.20		
Гурав. Төлөвлөлт, захирамжлалын баримт бичиг, байгууллагын үйл ажиллагаа					
3.1	Салбарын болон байгууллагын стратеги төлөвлөгөөний биелэлт	СБТГ	03.01		
3.2	Зэвсэгт хучийн байгуулалтыг 2024 он хүртэл хөгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө	ТЗУГ	10.25, 12.20	3Х-ий ХШҮГ	07.05, 12.20
3.3	Батлан хамгаалахын сайдас аймаг, нийслэлийн Засаг даргатай	СБТГ	12.25		
3.4	Байгууллагын тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт	ТЗУГ, харьяа	06.25, 12.15	3Х-ий ХШҮГ	07.05, 12.20

3.5	Батлан хамгаалахын сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлын төлөвлөгөө, хуралдааны шийдвэрийн биелэлт	ТЗУГ	улирал бурийн сүүлийн сарын 25	байгууллагууд	
3.6	Батлан хамгаалахын сайдын өгсөн үүргийн биелэлт	ТЗУГ	06.15, 12.10		
3.7	Сайд, Төрийн нарийн бичтийн даргын тушаалын биелэлт	ТЗУГ	Сар бурийн 30		
	Дөрөв. Байгууллагын үйл ажиллагаа				
4.1	Байгууллагын тухайн жилийн үйл ажиллагааны тайлан	ТЗУГ, харьяа байгууллагууд	02.01		
4.2	Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт	ТЗУГ	01.15	3Х-ий ХШҮГ	03.01
4.3	Байгууллагын ил тод байдлын шалгур үзүүлэлтийн биелэлт	ТЗУГ, харьяа байгууллагууд	02.20		
4.4	Өргөдөл, гомдолын шийдвэрлэлт	ТЗУГ	улирал бурийн сүүлийн сарын 25		
4.5	Яамны архив, албан албан хэрэг хөтлөлтийн дүрэм, журам, зааврын хэрэгжилт	ТЗУГ			
4.6	Ажлын байрны таатай орчны сэтгэл ханамжийн санал асуулгын тайлан	ЗХЖШ, яамны харьяа байгууллагууд	12.25		
4.7	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөвлөлийн үйл ажиллагааны тайлан, ёс зүйн зөрчлийн тухай мэдээ	Яамны харьяа байгууллагууд	улирал бурийн сүүлийн сарын 20		
4.8	Ёс зүйн зөрчлеөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, сурталчлан таниуллах сургалт, сурталчилгааны ажлын сарын мэдээ	Яамны харьяа байгууллагууд	сар бурийн 20-ны дотор		
4.9	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, дэг журам, сахилга, хариуцлагыг бэхжүүлэх салбар зөвлөлийн үйл ажиллагааны тайлан	ЗХЖШ, яамны харьяа байгууллагууд	улирал бурийн сүүлийн сарын 20		
4.10	Гэмт хэрэг, осол зөрчлийн сарын мэдээ	ЗХЖШ, яамны харьяа байгууллагууд	сар бурийн 20-ны дотор		

**БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ
ТАЙЛАГНАХ ХҮСНЭГТ**

№	Үндэслэж байгаа бодлогын баримт бичиг	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин		Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу гүйцэтгэлийн хувь (хүрээгүй бол шалтгаан, нэхцэл тайлбар)
				Он	Түвшин		
Бодлогын баримт бичгийн зорилго 1							
1.	Зорилт 1						/зорилт, арга хэмжээ тус бүрийн хэрэгжилтийг 2000 тэмдэгтэд багтаана. Зорилтот түвшиндээ хүрээгүй бол шалтгааныг бичнэ/
1.1.	Арга хэмжээ						
1.2.	Арга хэмжээ						
1.3.	Арга хэмжээ						
Бодлогын баримт бичгийн зорилго 2							
2.	Зорилт 2						
2.1.	Арга хэмжээ						
2.2.	Арга хэмжээ						
2.3.	Арга хэмжээ						

Аргачлалтын З дугаар хавсралт

**ЗАСГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБЕРИЙН
ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛГАНАХ ХУСНЭГТ**

ХӨГЖЛИЙН САЛБАР №1.1.						
ЗГҮАХ-т тусгагдсан зорилт		Дугаар		Хэрэгжих хугацаа		
1	2	3	4	5	6	7
Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Үндсэн хэрэгжүүлэх байгуулага	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх	Зорилтот түвшин, ур дун	Зорилтот түвшин, ур дун (хөрөнгийн хэмжээ эх үүсвэр)	Хэрэгжилтийн хувь
Дугаар			Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх	Хурсэн түвшин,	Зорилтот түвшин, ур дун	/зорилт, арга хэмжээ тус бурийн хэрэгжилтийг 2000 тэмдэгтэд батгаана. Зорилтот түвшинд хүрээгүй бол шалтгааныг бичнэ/
1	2	3	4	5	6	7
						9

ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН
ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ ХҮСНЭГТ

Шийдвэрийн дэс дугаар	Зүйл, заалтын дэс дугаар	Шийдвэрийн нэр, огноо, дугаар, агуулга	Хэрэгжилтийн явц	Үнэлгээ, (хүчингүй болсон, хяналтаас хасуулах тухай санал)	Тасарсан болон удааширч байгаа шалтгаан
1	2	3	4	5	6

Салбар чиглэл: 1

1.а. Монгол Улсын хууль

--	--	--	--	--	--

1.б. Улсын Их Хурлын тогтоол

--	--	--	--	--	--

1.в. Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол

--	--	--	--	--	--

1.г. Ерөнхийлөгчийн зарлиг

--	--	--	--	--	--

1.д. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, тэмдэглэл

--	--	--	--	--	--

1.е. Засгийн газрын тогтоол

--	--	--	--	--	--

1.ё. Ерөнхий сайдын захирамж

--	--	--	--	--	--

1.ж. Засгийн газрын хуралдааны тэмдэглэл

--	--	--	--	--	--

1.з. Засгийн газрын албан даалгавар

--	--	--	--	--	--

Хэсгийн дундаж: хувь

Салбар чиглэл: 2

2.а. Монгол Улсын хууль...

--	--	--	--	--	--

Хэсгийн дундаж: хувь

Нийт дундаж: хувь

ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН СУРГАЛТ, АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААГ
ХАНГАХ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТИЙГ ТАЙЛАГНАХ ХҮСНЭГТ (.... он)

№	Үйл ажиллагаа	№	Шалгур үзүүлэлт	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Тайлбар
Хүний нөөцийг хөгжүүлэх, идэвхжүүлэх						
1.	Засгийн газар, төрийн байгууллага, бусад байгууллагаас албан хаагчдын Мэдлэг, Мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан дотоод сургалт	1.1.	Нийт сургалт, семинар, зөвлөгөөний тоо: Үүнээс Ажлын байран дахь сургалт Мэргэшүүлэх сургалт Туршлага солилцох арга хэмжээ Бусад	Нийт сургалт, семинар, зөвлөгөөний тоо: Үүнээс Ажлын байран дахь сургалт Мэргэшүүлэх сургалт Туршлага солилцох арга хэмжээ Бусад	1. Нэг удаагийн сургалтын хугацаа 4 цагаас дээш бол тайлагнаа. 2. Зорилтот түвшин хэсэгт байгууллагын сургалтын төлөвлөгөөнд туссан дүнг бичнэ. 3. Гадаад улс орон, чандад хилийн хамрагдсан сургалтыг тайлагнаа.	1. Нэг удаагийн сургалтын хугацаа 4 цагаас дээш бол тайлагнаа. 2. Зорилтот түвшин хэсэгт байгууллагын сургалтын төлөвлөгөөнд туссан дүнг бичнэ. 3. Гадаад улс орон, чандад хилийн хамрагдсан сургалтыг тайлагнаа.
1.3.	Албан хаагчдыг сургалтад хамруулсан 90-ээс дээш байдал: Нийт албан хаагчдад эзлэх хувь				4. Дэлгэрэнгүй судалгаа Гүйцэтгэх, туслах албан тушаалтан Удирдах албан тушаалтан Эрэгтэй албан хаагч Удирдах албан тушаалтан Гүйцэтгэх, туслах албан тушаалтан	Тайландаа Хамрагдсан Сургалтыг Тайлагнаа.
2.	Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр байгууллагын	2.1.	Нийт гадаад сургалт, семинар, зөвлөгөөний тоо		Мэдээллийг хавсарласан тайландаа байна.	
		2.2.	Хамрагдсан нийт албан хаагчдын тоо:			

боловн зохион байгуулалтч тэлтүн зардаар хамруулсан гадаад сургалт	Үүнээс Эмэгтэй албан хаагч Эрэгтэй албан хаагч Удирдах албан тушаалтан	Эмэгтэй албан тушаалтч	
	Гүйцэтгэх, туслах албан тушаалтан		
2.3.	Гадаад сургалтад хамруулсан байдал: Нийт албан хаагчдад эзлэх хувь	20-оос дээш	Тайлант Гүйцэтгэлээр
3.	Албан хаагчдыг хөгжүүлэх, чиглэлээр зардал, албан шилжилт хаагчдын хөдөлгөөн	3.1. Албан хаагчдын сургалт, хөгжлийн УЙЛ - ажиллагаанд зарцуулсан зардлын хэмжээ (сая.төг)	
	3.2. Албан хаагчдын шилжилт хөдөлгөөний хувь	15-аас доosh	
Албан хаагчдын нийтмийн баталгааг хангах			
4.	Цалин хөлс, урамшууллын хэрэгжүүлэх	Шагнал, тогтолцоог хувь	Цалин, шагнал, урамшуулалд зарцуулсан - зардлын байгууллагын нийт төсөвт эзлэх хувь
		4.2. Нэгж албан хаагчид олгох хоол, унааны - нэмэгдэл (мян.төг)	
5.	Албан хаагчдын ажлын байрны хэвийн нөхцөлийг бурдүүлэх	5.1. Ажлын байрны таатай орчны сэтгэл ханамжийн санал асуулгын дун (Албан хаагчдын сэтгэл ханамж)	80-аас дээш
6.	Албан хаагчдын эрүүл мэндийг урьдчилан сэргийлэх	6.1. Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх урзлаг (Жилд)	1-ээс дээш
	6.2. Албан хаагчдын хамрагдалт	90-ээс дээш	Төрөлжсөн болон багч шинжилгээ
7.	Албан хаагчдыг нийгмийн баталгааг хангах чиглэлээр зарцуулсан зардал	7.1. Албан хаагчдын нийгмийн асуудалд - зарцуулсан зардлын хэмжээ (сая.төг)	Сайн дураар хамрагдах Тайлант Гүйцэтгэлээр

ИЛ ТОД БАЙДЛЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ ХУСНЭГТ

№	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилт Хувь
Нэг. Үйл ажиллагааны ил тод байдал		
1.	Эрхэм зорилго, Үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, Тэргүүлэх чиглэл болон ТЭДГЭЭРИЙН ХУРЭЭНД авч Хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн, зохион байгуулалтын бүтцийг цахим хуудас болон мэдээллийн самбартaa ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	
2.	Үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан албан хаагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч Уулзах цагийн хуваарийг цахим хуудас болон мэдээллийн самбартaa ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	
3.	Үйлчилгээ авахад шаардагдах бичиг баримтын жагсаалтыг цахим хуудас болон мэдээллийн самбартaa ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	
4.	Үйл ажиллагаандaa мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг цахим хуудас болон мэдээллийн самбартaa ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	
5.	Шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичиг болон захирагааны хэм хэмжээний актын шийдвэрийн төслийг цахим хуудсандaa 30-аас доошгүй хоног ойлгомжтой байдлаар байрлуулж, холбогдох төрийн ба төрийн бус байгууллага, мэргэжлийн шинжээч, эрдэмтэн, иргэдийн саналыг авах, үндэслэлтэй гэж үзвэл уг саналыг төсөлд тусгах;	
6.	Үзүүлж байгаа үйлчилгээний арга, хэлбэрийг боловсронгуй болгох зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх;	
7.	Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу төрийн байгууллагын гүйцэтгэх тодорхой чиг үргийг төрийн бус байгууллага гүйцэтгэж байгаа тохиолдолд тухайн төрийн бус байгууллагын нэр, хаяг, цахим хуудас, эрхэлж байгаа үйл ажиллагааны чиглэлийг цахим хуудас	

	боловн мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлэх;	
8.	Тухайн байгууллага тодорхой төрлийн аж ахуйн үйл ажиллагаа эсхүл бусад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгодог бол тухайн зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, эрхлэх үйл ажиллагааны чиглэл, зөвшөөрөл олгосон болон дуусгавар болох хугацааг цахим хуудсандaa ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бур шинэчлэх;	
9.	Салбарын хэмжээнд улсын төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусгамжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, явц, байдлын талаарх мэдээллийг цахим хуудсандaa байрлуулан тухай бур шинэчлэх;	
	Хэсгийн дундаж хувь:	
	Хоёр. Хүний нөөцийн ил тод байдал;	
1.	Сул орон тооны зарыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бур шинэчлэх, энэ тухай олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлах;	
2.	Албан хаагчийн ёс зүйн дурмийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бур шинэчлэх;	
3.	Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж, үнэлэх журмыг цахим хуудсандaa ойлгомжтой талаар байрлуулан тухай бур шинэчлэх;	
4.	Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар цахим хуудсандaa ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлж байх;	
5.	Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг үнэн зөв, шударга болгох чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар цахим хуудсандaa ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлж байх;	
	Хэсгийн дундаж хувь:	
	Хэрэгжилтийн дундаж хувь:	